



**БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН  
ТҮҮВЭР СУДАЛГАА  
2016 оны II улирал**

*Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан арилжааны банкуудын зээлийн төлөвийн талаарх түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнасан тул Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.*

**Улаанбаатар хот  
2016 оны 8 дугаар сар**


## 1. Оршил

- Судалгааны ажлын зорилго

Энэхүү түүвэр судалгааны зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын зээлийн үйл ажиллагаа, цаашдын төлөв ямар байгааг тодорхойлоход оршино.

- Судалгааны хамрах хүрээ, хугацаа

**Зураг 1: Банкуудын зээлийн хэмжээ**



- Банкны түүвэр судалгааг 2016 оны II улиралд Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй нийт 12 банкуудын дунд гүйцэтгэв.
- Уг түүвэр судалгааг банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан, шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнууд (Зээлийн хорооны гишүүн, зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар, хэлтсийн захирал)-ын дунд хийсэн.
- Судалгаанд оролцсон банкуудыг зээлийн хэмжээгээр нь том, дунд, жижиг гэж ангилан, судалгааны үр дүнг нийт банкууд болон дээрх ангиллаар задлан харууллаа.

Эх сурвалж: Монголбанк

- Аргазүйн товч тайлбар

Банкны түүвэр судалгаа нь зээлийн шалгуур, нөхцөл болон эрэлт гэсэн үндсэн гурван бүлэг асуултуудаас бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын хариултуудад 5 интервал бүхий [-1; +1] хоорондох утгуудыг харгалзуулж өгнө. Ингэхдээ банк тус бүрийн зээлийн үлдэгдлүүдийн хувийн жинг ашиглаж том, дунд, жижиг банкууд болон нийт системийн хувьд чиглэлийн индексийг тооцно.

**Хүснэгт 1: Индексийн тооцоолол**

Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн эрэлт	Нэлээд багассан	Бага зэрэг багассан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн	Нэлээд нэмэгдсэн


## 2. Түүвэр судалгааны үр дүн

### 2.1 Аж ахуйн нэгжийн зээл


- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн шалгуураа** чангаруулсан уу?

Нийт банкууд өнгөрсөн 6 сарын хугацаанд зээлийн шалгуураа нэлээд чангаруулсан гэжээ (өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг нэмэгдсэн байна, Зураг 2).

Зураг 2: ААН-ийн зээлийн шалгуур, банк



Зураг 3: ААН-ийн зээлийн шалгуур, салбар




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

Банкууд ХАА, боловсруулах болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан бол уул уурхай, барилгын салбарын зээлийн шалгуураа нэлээд чангаруулжээ (Зураг 3).

- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн шалгуураа чангаруулахад** юу нөлөөлсөн бэ?

Зураг 4: ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

Банкууд зээлийн шалгуураа чангаруулахад эдийн засгийн өсөлтийн сааралт, валютын ханш, тухайн салбарын төлөв байдал болон эх үүсвэрийн хомсдол голлон нөлөөлсөн гэжээ (Зураг 4).

- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн нөхцөлөө** чангаруулсан уу?

Судалгаанд хамрагдсан нийт банкууд өнгөрсөн 6 сарын хугацаанд зээлийн хүүгээ өсгөж, зээлийн хэмжээгээ бууруулж, хугацаагаа богиносгож, мөн барьцаа хөрөнгийн үнэлгээгээ бууруулан шаардлагаа нэмэгдүүлж зээлийн нөхцөлүүдээ бага зэрэг чангаруулсан байна (Зураг 5).

**Зураг 5: ААН-ийн зээлийн нөхцөл**





Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Өнгөрсөн 6 сарын хугацаанд том банкуудын зээлийн эрэлт нэлээд буурчээ. Харин жижиг банкуудын хувьд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн байна (Зураг 6).

**Зураг 6: ААН-ийн зээлийн эрэлт, банк**

**Зураг 7: ААН-ийн зээлийн эрэлт, салбар**



Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк


Банкууд уул уурхай, барилга болон боловсруулах, худалдаа үйлчилгээний салбар дахь зээлийн эрэлт буурсан гэж үзжээ (Зураг 7).

- Ирэх 6 сард **ААН-ийн зээлийн шалгуураа** хэрхэн өөрчлөх вэ?

Том болон жижиг банкууд ирэх 6 сарын хугацаанд бүх салбаруудын зээлийн шалгуураа чангаруулна (Зураг 8), тэр дундаа уул уурхай, барилгын салбар дахь зээлийн шалгуураа нэлээд чангаруулах төлөвтэй байна (Зураг 9).

Зураг 8: ААН-ийн зээлийн шалгуур, банк

Зураг 9: ААН-ийн зээлийн шалгуур, салбар




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

Барилгын салбарын зогсонги байдал болон орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байгаа нь банкууд барилгын салбарын зээлийн шалгуураа чангаруулахад нөлөөлсөн байх талтай.

- Ирэх 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн нөхцөлөө** хэрхэн өөрчлөх вэ?

Ирэх 6 сарын хугацаанд зээлийн хэмжээгээ бууруулж, хугацаа богиносгож зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулна гэсэн нь өмнөх судалгааны дүнтэй ойролцоо түвшинд байна (Зураг 10).

Зураг 10: ААН-ийн зээлийн нөхцөл, ирэх 6 сард





Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Ирэх 6 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдөх вэ?

Банкууд ирэх 6 сард томоохон ААН-үүдийн бизнесийн идэвхжил сэргэж зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна (Зураг 11). ААН-ийн зээлийн эрэлтийг салбараар нь авч үзвэл ХАА, боловсруулах болон худалдаа үйлчилгээний салбарын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэж үзжээ (Зураг 12).

Зураг 11: ААН-ийн зээлийн эрэлт, банк

Зураг 12: ААН-ийн зээлийн эрэлт, салбар





Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Бусад асуултууд

Эдийн засгийн идэвхжил буурсан, зах зээлийн эрсдэл нэмэгдсэн, валютын ханшийн тогтворгүй байдал нь зээлийн нийлүүлэлт буурахад голлон нөлөөлсөн гэж үзжээ (Зураг 13).

Зураг 13: ААН-ийн зээлийн нийлүүлэлт буурахад нөлөөлөгч хүчин зүйлс, давхардсан тоогоор

Зураг 14: ААН-ийн зээлийн эргэн төлөлт муудахад нөлөөлөгч хүчин зүйлс, давхардсан тоогоор



Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк


Бараа бүтээгдэхүүний борлуулалт муудсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдсан болон түүхий эд материалын зардал өссөн нь зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна гэж банкууд хариулжээ (Зураг 14).

## 2.2 Өрхийн зээл


- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **өрхийн зээлийн шалгуураа** чангаруулсан уу?

Нийт банкууд өнгөрсөн 6 сарын хугацаанд өрхийн зээлийн шалгууртаа төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна (Зураг 15).

Зураг 15: Өрхийн зээлийн шалгуур, банк



Зураг 16: Өрхийн зээлийн шалгуур, зориулалт




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **өрхийн зээлийн шалгуураа чангаруулахад** юу нөлөөлсөн бэ?

Нийт банкуудын хувьд өнгөрсөн 6 сарын хугацаанд өрхийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулахад эдийн засгийн өсөлт саарсан болон эх үүсвэр хомсдсон, түүнтэй холбоотойгоор эх үүсвэрийн өртөг өссөн зэрэг нь голлон нөлөөлжээ (Зураг 17).

Зураг 17: Өрхийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **өрхийн зээлийн нөхцөлөө** чангаруулсан уу?

Нийт банкуудын хувьд өнгөрсөн 6 сарын хугацаанд өрхийн зээлийн нөхцөлөө төдийлөн өөрчлөөгүй байна (Зураг 18).

Зураг 18: Өрхийн зээлийн нөхцөл




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк


- Өнгөрсөн 6 сарын хугацаанд **өрхийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Нийт банкуудын хувьд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Цалин, тэтгэвэр, малчны зээлийн эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд нэлээд нэмэгдсэн гэжээ (Зураг 19, Зураг 20).

Зураг 19: Өрхийн зээлийн эрэлт, банк



Зураг 20: Өрхийн зээлийн эрэлт, зориулалт



Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк




- Ирэх 6 сард **өрхийн зээлийн шалгуураа** хэрхэн өөрчлөх вэ?

Ирэх 6 сарын хугацаанд банкууд өрхийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах, тэр дундаа дунд банкууд нэлээдгүй сулруулах төлөвтэй байна. Харин жижиг банкуудын хувьд зээлийн шалгуураа чангаруулах сонирхолтой байна (Зураг 21).

Зураг 21: Өрхийн зээлийн шалгуур, банк

Зураг 22: Өрхийн зээлийн шалгуур, зориулалт




Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Ирэх 6 сард **өрхийн зээлийн нөхцөлөө** хэрхэн өөрчлөх вэ?

Нийт банкуудын хувьд ирэх 6 сарын хугацаанд өрхийн зээлийн нөхцөлөө төдийлөн өөрчлөхөөргүй байна. Гэвч банкууд барьцаа хөрөнгийн үнэлгээ шаардлагаа бага зэрэг нэмэгдүүлж, зээлийн хүүгээ бага зэрэг бууруулж магадгүй байна. Энэ нь эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан чанаргүй зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой байх талтай (Зураг 23).

Зураг 23: Өрхийн зээлийн нөхцөл, ирэх 6 сард





Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Ирэх 6 сарын хугацаанд **өрхийн зээлийн эрэлт** хэрхэн өөрчлөгдөх вэ?

Банкууд ирэх 6 сард өрхийн зээлийн эрэлт төдийлөн нэмэгдэхгүй гэсэн хүлээлттэй байна (Зураг 24). Өрхийн зээлийн эрэлтийг зориулалтаар нь авч үзвэл цалин, тэтгэвэр, хэрэглээний болон карт, хадгаламж барьцаалсан зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэж үзжээ (Зураг 25).

Зураг 24: Өрхийн зээлийн эрэлт, банк

Зураг 25: Өрхийн зээлийн эрэлт, зориулалт





Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

- Бусад асуултууд

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ муудсан, эх үүсвэрийн зардал, зах зээлийн эрсдэл нэмэгдсэн зэрэг нь зээлийн нийлүүлэлт буурахад голлон нөлөөлсөн гэж үзжээ (Зураг 26).

Зураг 26: Өрхийн зээлийн нийлүүлэлт буурахад нөлөөлөгч хүчин зүйлс, давхардсан тоогоор

Зураг 27: Өрхийн зээлийн эргэн төлөлт муудахад нөлөөлөгч хүчин зүйлс, давхардсан тоогоор



Эх сурвалж: Банкны зээлийн түүвэр судалгаа, Монголбанк

Бараа бүтээгдэхүүний борлуулалт муудсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдсан болон зээлийн хугацаа богино байгаа нь зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна гэж банкууд хариулжээ (Зураг 27).